

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН  
2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газар нь Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Үндэсний хөгжлийн цогц бодлогод суурилсан Мянганы хөгжлийн зорилт, Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд салбарын бодлого, зохицуулалтын үндсэн чиглэл, зорилтуудыг ханган биелүүлэхэд чиглэсэн тус газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллалаа.

Тус газраас 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 5 зорилтод суурилсан 162 бүтээгдэхүүн, ажил тусгаснаас дор дурьдсан төлөвлөгөөт болон Засгийн газраас яаралтай хийж хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтот ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**Нэг. Харилцаа холбоо, шуудангийн салбарын хөгжлийн бодлого, дэвшилтэт технологи, өргөн нэвтрүүлэг, радио давтамжийн чиглэлээр стратегийг төлөвлөх, дэвшилтэт технологийг нутагшуулах бодлогын удирдамжаар хангах**

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын 2015 оны нээлттэй өдөрлөгийг “Төр, хувийн хэвшлийн түншлэл” уриан дор 2015 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Төрийн ордонд зохион байгууллаа. Уг өдөрлөгөөр үүрэн холбооны оператор компаниуд, Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын шуудангийн холбоо, Их дээд сургуулийн төлөөлөл, Монголын телевизүүдийн холбоо, Мэдээллийн тэргүүлэх сайтуудын холбоо, Мэдээлэл холбооны дэд бүтэц, угсралтын ажил эрхлэгчдийн холбоодын төлөөллүүд энэ салбарт тулгамдаж буй асуудлууд, цаашид хэрхэн шийдвэрлэх арга замын талаар илтгэл тавьж, яам, агентлаг, төрийн болон төрийн бус нийт 160 гаруй байгууллагаас 900 орчим төлөөлөгчид оролцлоо.

Тус газраас 2015 оныг “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн жил” болгон зарласантай холбогдуулан төр хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг сайжруулах бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Салбарын хууль эрхзүйн шинэчлэлийн ажлын хэсэг, Харилцаа холбоо, шуудангийн ажлын хэсэг, Мэдээллийн технологийн ажлын хэсэг, Үндсэн сүлжээний ажлын хэсэг, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллалаа.

Монгол Улсын “Шилэн дансны тухай” хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг тус газрын даргын тушаалаар байгуулан 2014 оны 12 дугаар сарын 19-өөс 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал төрийн бүх шатны байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Уг ажлын хэсгийн тайланг гаргаж, удирдлагад танилцуулсан.

“Төрийн үйлчилгээний цахим машины талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2015 оны 23 дугаар тогтоол, “Төрийн үйлчилгээг үзүүлэх цахим системийн талаар авах арга хэмжээний тухай” ЗГ-ын 2015 оны 254 дүгээр тогтоолыг тус тус батлуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Цахим гарын үсгийн гэрчилгээ олгох ажлын хүрээнд:

- Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс “МУ-д цахим гарын үсгийн талаар төрөөс баримтлах чиглэл” баримт бичгийн төсөл, “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулах журам”-ын төслийг тус тус боловсруулан газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, газрын даргын тушаалаар батлуулав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг сонгон шалгаруулан үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.
- Тоон гарын үсгийн системийн ашиглалтад орох хугацаа болон зохион байгуулалтын ажлын талаар санал солилцохоор тоон гарын үсэг олгох төслийн гүйцэтгэгч багийн гишүүдтэй уулзалт зохион байгуулав. Тоон гарын үсгийг төстийн хүрээнд ТЕГ болон НДЕГ дээр эхний ээлжинд туршилт хийхээр төлөвлөн, НДЕГ-ын 7 үйлчилгээг төстийн шатанд оруулахаар Үндэсний дата төв УТҮГ-тай хамтран ажиллаж байна.
- “Цахим гарын үсгийн тухай” хуулийг хэрэгжүүлэх “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглах талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах” ажлын хэсгийг газрын даргын 2015 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 44 дүгээр тушаалаар байгуулан “Монгол Улсад Цахим гарын үсгийн талаар төрөөс баримтлах бодлогын чиглэл” боловсруулан газрын Удирдлагын зөвлөлийн 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, газрын даргын 2015 оны 71 тоот тушаалаар батлууллаа.
- ХХЗХ-ноос боловсруулсан ЦГҮ-ийн гэрчилгээ эзэмшигчийн мөрдлөг болгон ажиллах журамд холбогдох саналаа хүргүүлэв.

Олон Улсын цахилгаан холбооны байгууллагын 2010 оны Бүрэн эрхэт төлөөлөгчдийн бага хурлаар батлагдсан Үндсэн дүрэм, конвенцийн нэмэлт өөрчлөлтийг Улсын Их Хурлаар соёрхон батлууллаа.

“Төрөөс Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын төслийг боловсруулан, УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, УИХ-д өргөн бариад байна.

Үндсэн сүлжээний бодлого тодорхойлох ажлын хүрээнд “Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл” -ийг боловсруулан 2015 оны 1-р сарын 13-ны өдөр тус газрын Даргын зөвлөлийн хурлаар

хэлэлцүүлэн газрын даргын 10 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

“Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын 2015-2017 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө”-г боловсруулан газрын даргын 2015 оны 194 дүгээр тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

Засгийн газрын 2011 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ” үндэсний хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дуусч байгаатай холбогдуулан хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, шинэ хөтөлбөр боловсруулахаар эхний төслийг бэлтгээд байна.

“Төрөөс Монгол Улсын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрөх улс хоорондын мэдээлэл, харилцаа холбооны транзит урсгал дамжуулах бизнесийг хөгжүүлэх баримтлах бодлогын баримт бичиг”-ийн төслийг боловсруулаад байна.

Төрийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэхээр ЗГ-ын 2013 оны 212 дугаар “Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам батлах тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлээд байна.

Төрийн үйлчилгээг цахим машин болон цахим систем ашиглан хүргэхэд үйлчилгээний хөлснөөс гадна гарах өртөг, зардлыг баталгаажуулах эрх зүйн орчныг бий болгохоор “Төрийн үйлчилгээг цахимаар хүргэхэд гарах өртөгийг тооцох журам”-ын төслийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлээд байна.

“МТШХХГ-ын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг хадгалах, хамгаалах, ашиглах түр журам”-ыг газрын даргын 2015 оны 15 дугаар тушаалаар батлуулан сан үүсгэн ажиллаж байна.

Тус газрын даргын 2014 оны 15 дугаар тушаалаар байгуулагдсан харилцаа холбооны салбарын хууль эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох ажлын хэсэг ажиллаж байна.

- Харилцаа холбооны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Шуудангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
- Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төсөл
- Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төсөл

“Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридор” байгуулах тухай БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлийн хорооноос ирүүлсэн баримт бичгийн төсөлд Ази-Европыг холбосон Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх улс хоорондын интернэт транзит

урсгалын хэмжээг нэмэгдүүлэх талаар тусгайлсан заалт оруулах талаарх саналыг боловсруулан хүргүүлэв.

Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2006 оны 16 дугаар тушаалаар батлагдсан “Шуудангийн марк, үнэт цаас үйлдвэрлэх, борлуулах журам”-ын 2.1-ийн а-д заасны дагуу Монгол Улсын 2016-2017 онд хэвлэгдэн гүйлгээнд гарах шуудангийн маркийн сэдвийн төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий сайдын 134 дүгээр захирамжаар батлуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Програм хангамжийн бичил компаниудын үйл ажиллагааны циклийн горимын талаар ISO29110 таван багц стандартыг орчуулан, Мэдээллийн технологийн Үндэсний паркийн инкубаторын компаниудын дунд хэлэлцүүлэг хийж, санал авч, стандартыг 5 дугаар сарын 21-нд Үндэсний Стандартын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.

Монгол Улсын 2015 оны Төсвийн тухай хууль хэлэлцэх явцад БСШУЯ-ны харьяа сургуулиудын интернэт болон бусад үйлчилгээнд зориулагдсан зардал болох 1,016 сая төгрөгийг тус газрын 2015 оны урсгал зардлын төсөвт тусгасны дагуу Ерөнхий боловсролын сургуулиудад интернэтийн үйлчилгээг хүргэхээр МХС ТӨК, Эрдэмнэт ХХК, МЦХ ХК, Юнивишн ХК, БСШУЯ-тай хамтарсан 3 талт Интернэтийн үйлчилгээ үзүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, үйлчилгээг тасалдалгүй явуулж байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын 2014 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 09 дүгээр захирамжаар байгуулсан “Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлын үндэсний бодлого, эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах” ажлын хэсэгт тус газраас төлөөлөл ажиллаж, Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн болон үзэл баримтлалын төсөлд санал өгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд хүргүүлэв.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл боловсруулах ажлын хүрээнд 2016 онд хэрэгжүүлэх 8 төслийн санхүүжилтийн мэдээллийг боловсруулан, МХХ-ны салбарын болон төслийн танилцуулгын хамт Сангийн яаманд хүргүүлээд байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны хурлаар болон Монгол Улсын Засгийн газраар 2015 онд хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг тус тус гарган Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Монгол Улсад интернэтийн сүлжээг дараа үеийн интернэт протокол хувилбар 6-д (IPv6) суурилсан сүлжээнд шилжүүлэх бодлого, зохицуулалтын чиглэл, төлөвлөлтийн талаар санал боловсруулах ажлын хэсэг ажиллаж, судалгаа хийн, интернэтийн үйлчилгээ үзүүлдэг компаниудад хүргүүлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 137 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний хиймэл дагуул” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд МУ-ын Ерөнхий сайдын 58 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Харилцаа холбооны хиймэл дагуул хөөргөж ашиглах чиглэлээр хамтран ажиллах санал ирүүлсэн Эйрбус дефенс энд спейс (Airbus Defence and Space), Талес алейна спейс (Tales Aleina Space) Эйшан бродкаст сателит (Asian Broadcasting Satellite) компанийн төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулж, санал солилцлоо.

Иргэдийг баталгаажсан тоон телевизийн хэрэглэгчийн төхөөрөмжөөр хангах зорилгоор 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр хэрэглэгчийн хувиргагч төхөөрөмж нийлүүлэх, үйлдвэрлэх эрх авсан нийт 7 байгууллагатай уулзалт байгуулав. Тус уулзалтын хүрээнд хамтран ажиллах санал солилцон, хэрэглэгчийн хувиргагч төхөөрөмжийг нийлүүлэх арга замын талаар хэлэлцэн Харилцаа холбооны зохицуулах хорооноос тохирлын тэмдэг олгох ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Өнөөгийн байдлаар аналог болон тоон нэвтрүүлэгч 371 сум суурин газарт зэрэг ажиллаж байгаа ба энэ нь хязгаарлагдмал нөөц болох радио давтамж чөлөөлөгдөхгүй, эдийн засагт эрчим хүчний зардал нэмэгдсэн, оролтын үүсгүүр дохионы чанар сарних, нэвтрүүлэгч хоорондын харилцан нөлөөлөл, антенн фидерийн давхцал үүсэх зэрэг хүндрэл үүсгэж байгаа тул аналог нэвтрүүлэгчийг унтраах хугацаат хуваарийг боловсруулан 2015 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, газрын даргын тушаалаар “Тоон өргөн нэвтрүүлгийг сурталчлан таниулах 2015 оны төлөвлөгөө”, “Монгол Улсын аналог телевизийг дахин дамжуулах станцуудыг унтраах хуваарь”-ийг газрын даргаар тус тус батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Монгол Улсын телевизийн өргөн нэвтрүүлгийг аналог системээс тоон системд шилжүүлэх ажил” ХААГ-Б-2014/VIII-39 төслийн гүйцэтгэгч Ай Ти Зон ХХК-тай уулзалт хийж суурилуулалт хийгдээгүй 7 сайтад суурилуулалтын ажлыг гүйцэтгүүлэх, хажуугийн цацаргалтын нөлөөлөл илэрч байгаа 28 сайт дээрх нөлөөллийг арилгах, 11 сайт дээр шүүлтүүр тавих, Ховд аймгийн Булган сум, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сум, Говь-Алтай аймгийн Цээл суманд суурилуулсан тоон телевизийн дахин дамжуулах станцын хүлээн авагч нэвтрүүлэгчид үүссэн гэмтлийг арилгах, гарын авлага боловсруулах, тараах, филтерийн нөөц үүсгэх, дээрх 39 сайтын нөлөөллийг арилгаж, ажлын явцыг газрын удирдлагад мэдээлэн ажиллаж байна.

Интернэт протоколд суурилсан ТВ-ийн талаар баримтлах бодлого шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг газрын даргын тушаалаар байгуулан, бодлогын баримтлах чиглэлийг шинэчлэх талаар судалгаа хийж байна.

Дэлхийн радио холбооны дүрэмд орох өөрчлөлт, шинэ техник технологийн судалгаатай холбоотой дараах ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- ОУЦХБ-аас ирүүлсэн албан бичгүүдтэй танилцан судлах, хариу өгөх
- "ITU-TIES ACCOUNT" мэдээллийн сүлжээгээр болон ОУЦХБ-ын судалгааны ажлын хэсгийн вэб сайтууд, Ази-Номхон Далайн орнуудын бэлтгэл хурлын (APG15-4) үр дүн болон DRAFT CPM текстийн судалгаанд оролцох

Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас манай улсад хуваарилсан геостационари орбит дахь хиймэл дагуулын байрлалыг гадны хиймэл дагуулын сүлжээний нөлөөнөөс хамгаалах ажлыг BRIFIC програм хангамжийн тусламжтай тогтмол гүйцэтгэж байна.

ОХУ-ын Радио давтамжийн төв болон ОУЦХБ-аас ирүүлсэн хиймэл дагуулын координаци болон хил орчмын радио давтамжийн зохицуулалттай холбоотой албан тоотод ХХЗХ-той хамтран холбогдох боловсруулалт, тооцооллыг хийж хариуг хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор “Хиймэл дагуул - Бидний гараар” уриатай “КАНСАТ” үндэсний гуравдугаар тэмцээнийг 2015 оны 6 дугаар сарын 6-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Уралдаанд нийт 5 их дээд сургуулийн 7 баг өрсөлдсөн бөгөөд нийт оролцогч багуудыг мэдээлэл холбооны тэргүүлэгч компаниуд болох Ддиш ТВ ХХК, “Мэдээлэл Холбооны Сүлжээ” ТӨК, “Монголын Цахилгаан Холбоо” ХК, Исатком компани, Монкабель Системс ХХК ивээн тэтгэн оролцлоо. Мөн “Кансат” нэртэй 30 минутын 8 цуврал нэвтрүүлэг хийлгэн, олон нийтэд сурталчлав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Шинжлэх Ухааны Академийн харъяа Үндэсний хөгжлийн хүрээлэн, Японы Кэио их сургуулийн Байгаль орчны удирдлагын менежментийн сургууль, Газрын харилцаа геодези зурагзүйн газар хамтарсан “Үндэсний орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх түүнийг орон нутгийн болон улсын хөгжлийн бодлого төлөвлөлтөд ашиглах нь” сэдэвт семинарт “Мэдээлэл харилцаа холбооны салбарт орон зай мэдээллийн системийг ашиглах нь” сэдвээр илтгэл тавьж оролцлоо.

Нийслэлийн мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж, “Орон сууцны зориулалттай барилгын дотор мэдээлэл, холбооны сүлжээ байгуулах техникийн шаардлага”-ын стандартад саналаа боловсруулан, хүргүүлэв.

“Холбооны цамхаг байгуулахад тавих ерөнхий шаардлага” MNS 5884:2008, “Дата төвийн цахилгаан холбооны дэд бүтцийн стандарт”, “Шилэн кабелийн суурилуулалтад ашиглах хэмжүүрийн багаж, тоног төхөөрөмжийн стандарт” -ын төслүүдэд тус тус саналаа хүргүүлэв.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Өргөн нэвтрүүлгийн болон кабелийн сувгийн, Олон сувгийн үйл ажиллагаа эрхлэгч телевизийн үйл ажиллагаанд

боловсруулалт хийж, орон нутаг, Улаанбаатар хотод үйлчилгээ эрхлэгчээр нь ангилж тоон хуваагдлын судалгааг хийлээ.

"Хурдан морины бүсийн уралдааны 2015 оны хуваарийг тогтоох тухай" Засгийн газрын 2015 оны 33 дугаар тогтоолын дагуу зохион байгуулсан "Дүнжингарав-2015" морин уралдааны харилцаа холбооны техникийн бэлэн байдлыг тус газар хариуцан ажиллалаа.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын сансрын аюулгүй байдлын зөвлөл тус газартай хамтран Монгол Улсад 2016 оны гуравдугаар улиралд "Сансрын технологи, гамшгийн менежмент" сэдэвт семинарыг Улаанбаатар хотод зохион байгуулахаар төлөвлөн, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Үндэсний роуминг үйлчилгээний талаар 4 оператор компаниас бааз станцуудын талаар мэдээлэл авч, оператор компаниудын хамрах хүрээний давхардлын талаар судалгаа хийж байна.

АСЕМ -ийг зохион байгуулах харилцаа холбооны дэд ажлын хэсгийн хүрээнд ҮДТ УТҮГ, КАБГ -ын төсвийг зохих журмын дагуу эцэслэн хүргүүлээ. Үндэсний зөвлөлөөс ҮДТ УТҮГ -ын шаардлагатай тоног төхөөрөмжийг Европын холбооны орнуудын тусламжийн хүрээнд шийдвэрлэх санал гаргаад байна.

БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар алслагдсан сумдын малчин өрхүүдийг хйимэл дагуулын телевизийн зөөврийн хүлээн авагч болон нарны эрчим хүчний төхөөрөмжөөр хангах "Малчны дэлгэц" төслийн баримт бичгийг Монгол, Англи хэл дээр боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн. Төслийн баримт бичгийг Сангийн яамнаас БНХАУ-ын ЭСЯ-нд уламжлаад байна.

Монгол Улсын телевизийн өргөн нэвтрүүлгийг аналог системээс тоон системд үе шаттай шилжүүлэх төслийн гэрээний үлдэгдэл ажил болох тоон өргөн нэвтрүүлгийн дотоодын сургалт хийгдээгүй үлдсэн тул сургалтыг зохион байгуулж гэрээний гүйцэтгэлийг бүрэн хангуулах талаар Ай Ти Зон ХХК руу албан тоотыг хүргүүлж, сургалтыг зохион байгуулах талаар хэлэлцэж байна.

БНФУ-ын Сансар судлалын төвтэй харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулах талаар ЗГХЭГ-т дахин танилцуулахаар саналаа боловсруулж байна. Мөн санамж бичгийн төсөлд холбогдох яамдаас санал авч байна.

Монгол шуудан ТӨХК-аас шуудан тээврийн өвлийн хуваарийг боловсруулан Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргаар батлуулахаар хүргүүлээд байна.

2G, 3G сүлжээнд буюу Internet, SMS хэлбэрээр Сонгуулийн санал өгөх асуудалтай холбоотойгоор хууль эрхзүйн судалгааг хийж газрын даргад танилцуулав.

**Хоёр. Мэдээллийн технологийн инновацид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээний үйлдвэрлэл, хөгжүүлэлт болон хэрэглээг нэмэгдүүлэх тогтолцоог бий болгох, цахим засаг, төрийн бүртгэл мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох. бодлогын удирдамжаар хангах**

“Цахим засаг” үндэсний хөтөлбөр, Монголын програм хангамж үйлдвэрлэлийн салбарын 2 дугаар чуулганаас дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн мэдээллийг цахимжуулах, цахим мэдээллийн санг өргөжүүлэх, үйлчилгээг цахим хэлбэрээр [www.ezasag.mn](http://www.ezasag.mn) сайтаар дамжуулан, иргэд албан байгууллагуудад хүргэх арга хэмжээг концессийн барих-ашиглах-шилжүүлэх хэлбэрээр дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудаар хэрэгжүүлэх шийдвэрийг Засгийн газрын 2015 оны 254 дүгээр тогтоол, 2015 оны 411 дугаар тогтоолоор тус тус шийдвэрлүүлээд байна. Энэхүү шийдвэрийн үр дүнд концессийн жагсаалтанд “Төрийн үйлчилгээний цахим системийг хөгжүүлэх төсөл” гэсэн шинэ ангиллыг тусгаж, төрийн 167 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх боломжийг бүрдүүлээд байна.

Програм хангамж үйлдвэрлэлийн салбарыг дэмжих зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Монголын програм хангамж үйлдвэрлэлийн салбарын 3 дугаар чуулган”-ыг Монголын Програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо (МОСА), Мэдээллийн Технологийн Үндэсний Парктай хамтран 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр “Дэлхийд Танигдъя” уриатайгаар амжилттай зохион байгуулав. Чуулганаас гарсан зөвлөмж болон “Програм хангамжийн Старт-ап буюу Гарааны бизнесийг хөгжүүлэх” үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж байна.

Төрийн мэдээллийн нэгдсэн сангийн ашиглалт үйлчилгээг сайжруулах, одоо мөрдөгдөж буй тогтоол шийдвэр, дүрэм журмыг шинэчлэн боловсруулах журмын төсөл боловсруулах ажлын хэсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Үндэсний дата төв УТҮГ-ын бүрэлдэхүүнтэйгээр тус газрын даргын 2015 оны 100 дугаар тушаалаар байгуулав. Ажлын хэсгийн хүрээнд төрийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, төрөөс иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлэх цахим үйлчилгээний суурь нөхцлийг бүрдүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 212 дугаар тогтоолын хавсралт “Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам”-д зохих нэмэлт, өөрчлөлт оруулж, Үндэсний дата төвийн Бүртгэлийн хэлтсийн чиг үүргийг нэмэгдүүлж өгсөн. Ажлын хэсгийн тайланг бичиж, удирдлагуудад танилцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын “Төрийн үйлчилгээний цахим системийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 254 дүгээр тогтоол, “Төрийн өмчийн концессийн



зүйлийн жагсаалт” батлах тухай 2013 оны 317 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай 2015 оны 411 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг “Концесс олгох уралдаант шалгаруулалт”-аар хийж гүйцэтгүүлэхээр ажиллаж байна. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх техник, эдийн засгийн урьдчилсан судалгааны ажлын даалгавар боловсруулахад шаардлагатай суурь судалгааны мэдээлэл цуглуулах хүснэгтийн боловсруулж, жагсаалтад багтсан үйлчилгээ эрхлэгч 24 байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж байна. Үндэсний дата төв УТҮГ-тай хамтран Үндэсний Статистикийн хороо, Эрүүл мэнд, спортын яам, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Нийслэлийн татварын газар, Нийслэлийн архивын газар, Нийслэлийн өмчийн харилцааны газарт концесс олгох уралдаант шалгаруулалт, үйлчилгээний үнэ хөлс тогтоох, технологийн бэлэн байдлын талаар мэдээлэл өгч, танилцуулга хийв.

Цахим гүйлгээний төлбөр төлөлтийн холболтын үндсэн процессын зураглалыг гаргаж, санал авахаар Монгол банкинд хүргүүлэв.

“Төрийн үйлчилгээний цахим төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ”-ний төсөлд саналаа тусгаж, хамтран ажиллах хүсэлтийг ЦЕГ болон ЦЕГ-ын Лицензийн төвд тус тус хүргүүлэв.

БНСУ-ын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-аас Монгол Улсад хэрэгжүүлсэн нийт 15 төсөлд үнэлгээ хийсэн ба уг төслүүдийн үр дүн, үзүүлэлтийг хэлэлцүүлэх хурлыг 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Төслийг нэгээс дөрөв гэсэн оноогоор үнэлж, төрийн байгууллагын мэргэжилтэн, дарга нараас ярилцлага авч нэгдсэн үнэлгээг гаргасан ба цахим засгийн тогтолцоо, техник дэд бүтэц, боловсон хүчин, цахим засаглалын үйлчилгээ зэрэг үзүүлэлтүүдээр төслүүдийн цахим засаглалд үзүүлсэн үр дүн, стратегийн, ардчилсан байдлын, нийгэм соёлын, эдийн засгийн, засаглалын ач холбогдол зэрэг үзүүлэлтээр үр дүнг үнэлсэн. Цахим засаглалд үзүүлсэн үр дүн 3.54, МУ-ын хөгжилд үзүүлсэн үр дүн 3.64 үзүүлэлтэй үнэлэгдлээ.

“Төрийн үйлчилгээний нэгдсэн веб порталын модулиуд хөгжүүлэлт төсөл”-ийн хүрээнд төлбөр тооцоог гүйцэтгэх цахим хуудасны мэдээллийн технологийн дэд бүтэц (сүлжээ, техник, програм хангамж), түүгээр дамжин хийгдэж буй гүйлгээний дамжуулалт, боловсруулалтыг Монгол банкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын Үндэсний цахим гүйлгээний төв хариуцан ажиллах болсонтой холбогдуулан Монгол банктай хамтран ажиллах гэрээний төслийг хянан нэмэлт, өөрчлөлт оруулан тус банкинд хүргүүлээ.

Төрийн цахим үйлчилгээний портал [www.ezasag.mn](http://www.ezasag.mn)

- 25 үйлчилгээ
- Төрийн 167 үйлчилгээ

“Төрийн үйлчилгээний цахим машины талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2015 оны 23 дугаар тогтоолоор батлуулж, ТҮЦ машинаар иргэдэд хүргэх үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, ТХХТ-ээр ТҮЦ машины үйлчилгээг хүргэх, ТҮЦ машинд шинээр үйлчилгээ нэмэх эрх зүйн орчин бий болсон.

Төрийн 167 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд:

- Газрын даргын 2015 оны 80 дугаар тушаалаар төрийн үйлчилгээг шат дараатайгаар цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн үйлчилгээний цахим системд үйлчилгээ нэмж оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.
- ТҮЦ машин болон төрийн үйлчилгээний цахим системд оруулах боломжтой үйлчилгээний талаар 60 байгууллагаас санал авахаар танилцуулгыг хүргүүлснээс 50 байгууллагаас хариу хүлээн авч, төрийн 167 үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн гаргалаа. Судалгаанд хамрагдсан 24 байгууллагаас нийт 74 үйлчилгээний санал ирсэн ба 26 байгууллага саналгүй гэсэн хариу ирүүлэв. Судалгаанаас үзэхэд 11 байгууллагын 15 үйлчилгээ нь цахим өгөгдлийн сантай, бусад үйлчилгээнүүд MS Excel суурьтай, цаасан суурьтай байна. 9 үйлчилгээ удахгүй цахим өгөгдлийн сантай болохоор бэлтгэл ажил хийж байгаа талаар мэдэгдсэн болно.

Швейцарийн хөгжлийн агентлагийн Хүний аюулгүй байдлын судалгааны төвтэй хамтран байгуулсан санамж бичгийн хүрээнд Төрийн Үйлчилгээний Цахим (ТҮЦ) машины хэрэглээ, оновчтой байрлал, цаашид авах арга хэмжээг тодорхойлох судалгааг хөндлөнгийн мэргэжлийн судалгааны “Оч Ментор” ХХК-аар хийлгэлээ.

Тус газрын даргын 2015 оны 12 дугаар тушаалаар “Улаанбаатар төмөр зам” Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэгтэй 2015 – 2016 онд Мэдээлэл технологи, шуудан, харилцаа, холбооны чиглэлээр хамтран ажиллах, бодлогын зөвлөмж боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг Улаанбаатар төмөр замын мэдээллийн технологийн холбогдох хүмүүс, Үндэсний Дата төвийн мэргэжилтнүүдтэй ТҮЦ машинд төмөр замын билетийн захиалгыг оруулах талаар санал солилцож, үнэ төлбөр болон боломжийн талаарх судалгаа хийж байна.

Тус газраас “Цахим засаглалын мэдээллийн сан, мэдээллийн системийг бий болгох төсөл”-ийнхүрээнд улсын төсвийн санхүүжилтээр 2012-2014 онд хэрэгжүүлсэн “Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хянах мэдээллийн системийг бий болгох”, “Иргэдийн өргөдөл гомдлын мэдээллийн ухаалаг тайлангийн систем” төслүүдийн тайланг боловсруулан, нэгтгэж Үндэсний аудитын газарт хүргүүлэв.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цахим систем болон Мобайл технологид суурилсан програм хангамжийн нэгдсэн үйлчилгээний портал систем хөгжүүлэх” төслийг хэрэгжүүлэн Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газраас Үндэсний дата төв УТҮГ-т байрлуулсан цахим мэдээллийн сангийн серверийг бичих ажлыг хийж байна. Мөн Иносолюшн ХХК-тай хамтран Зам тээврийн яамны бизнес процессыг шинэчлэхээр ажиллаж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын 2010 оны 141 дүгээр тоот тогтоолоор батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2011 оны 312 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн захиргааны төв байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэхээр Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2015 оны 37 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллалаа. Ажлын хэсэг нийт төрийн захиргааны төв 61 байгууллагуудад Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дүрэм, журам, стандарт, хөрөнгө оруулалт, Хүний нөөцийн мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг чадвар, Програм хангамжийн эрсдэл, Өгөгдлийн сан, мэдээлэл солилцох эрсдэл, Техник хангамжийн эрсдэл, Сүлжээний эрсдэл, Орчны эрсдэл, Цахим хуудас, цахим шуудангийн аюулгүй байдлын эрсдэл гэх мэт шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт хийж, үнэлгээний тайлан гаргаж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан ЗГХЭГ, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлээ.

Төрийн мэдээллийн нээлттэй өгөгдлийн цахим системийг бий болгох, төрийн байгууллагуудаас нээлттэй тавьж болох мэдээллийн жагсаалтыг гаргах, улмаар иргэдийг мэдээллээр хангах ажлын хэсгийг тус газрын даргын 2015 оны 35 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд нээлттэй өгөгдлийн SKAN платформ дээр [www.data.gov.mn](http://www.data.gov.mn) цахим хуудсыг нээн ажиллуулж эхлээд байна. Тус цахим хуудсанд эхний ээлжинд МТҮП болон МТШХХГ-ын нээлттэй мэдээлж болох өгөгдлүүдийг тавиад байгаа бөгөөд цаашдаа бусад төрийн байгууллагуудад нэвтрүүлнэ. Мөн нээлттэй өгөгдлийн систем ажиллаж буй SKAN платформын орчуулгыг дахин хянах, цахим хуудасны дизайныг сайжруулах, төрийн нээлттэй өгөгдлийн журмын төслийг боловсруулж байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын 2014 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 09 дүгээр захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлын үндэсний бодлого, эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах” ажлын хэсэг ажиллаж Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөлд өөрчлөлт оруулах асуудлаар ажлын хэсгийн гишүүдтэй санал солилцож боловсрууллаа.

Улаанбаатар хотын 2030 хүртэлх ерөнхий төлөвлөгөөний дагуу шинэ суурьшлын бүс болон орон сууцны шинэ хорооллууд олноор баригдаж байгаатай холбогдуулан "Мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн үйлчилгээний төв, хороолол, хотхоны мэдээлэл, харилцаа холбооны байр, барилга, орон сууцны техникийн өрөөнд тавигдах үндсэн шаардлага"-ыг боловсруулж, Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар болон Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХК-д тус тус хүргүүлэв.

Төрийн байгууллагуудын зүгээс аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудад хийгдэх хяналт, шалгалтын талаар шийдвэр гаргагчдад мэдээлэх зорилго бүхий [www.shilenkhyanal.gov.mn](http://www.shilenkhyanal.gov.mn) цахим хуудасны домэйн нэр болон зохиомол сервер үүсгэх ажлыг Үндэсний дата төвтэй хамтран зохион байгуулав. Мөн төрийн байгууллагуудын зүгээс аж ахуйн нэгж байгууллагад хийдэг хяналт, шалгалтын тоо болон тэдгээрийн давтамжийн талаарх мэдээллийг гарган гүйцэтгэгч компани Интерактив ХХК-д хүргүүлэв.

Монгол Улсад 2016 онд зохион байгуулагдах Ази-Европын (АСЕМ) 11 дүгээр Дээд түвшний уулзалтын бэлтгэл ажлыг хангах хүрээнд харилцаа холбооны салбараас хийх ажлын төлөвлөгөө болон шаардлагатай хөрөнгө оруулалтын төсвийн төслийг боловсруулан Гадаад хэргийн яам болон Зам тээврийн яаманд тус тус хүргүүлж, хамтран ажиллаж байна.

Нисэх, Яармаг чиглэлийн 55000 хүн ам суурьших орон сууцны шинэ хороололд байгуулах мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн үйлчилгээний төвийн барилгад тавигдах ерөнхий шаардлага, орон сууцны хорооллын дунд байрлах холбооны барилгын болон орон сууцны барилгын подвалд байрлах мэдээлэл, холбооны техникийн өрөөний төлөвлөлтийн нөхцөл, шаардлагыг боловсруулж Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар, Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХК-д тус тус хүргүүлээ.

Уул уурхайн сайдын 2015 оны 63 тоот тушаалаар байгуулагдсан ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгож байгаа үйл ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэгт тус газраас орж ажиллан, цахимаар дугаар олгох үйл ажиллагаатай танилцаж холбогдох тайланг гарган хүргүүлэв.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/58 дугаар тушаалаар байгуулагдсан "Даатгуулагч, шимтгэл төлөлт, даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын төлбөрийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сангийн дүрэм, Цахим картны загвар, цахим картад хадгалагдах мэдээлэл, цахим картыг хэрэглэх журам"-ын төслийг боловсруулж байна

"Төрийн үйлчилгээний нэгдсэн вэб порталын модулиуд хөгжүүлэлт" төслийн хүрээнд:

- Төслийн гэрээ байгуулагдсанаас хойш хийж гүйцэтгэсэн ажлууд, төслийн хүрээнд хамтарч ажилласан байгууллагууд, тухайн байгууллагууд дээр хийгдсэн ажлууд, сургалт зохион байгуулсан газрууд, төслийн одоогийн байдал, удааширч байгаа шалтгаан, санхүүжилт зэрэг мэдээллүүдийг багтаасан тайланг боловсруулав.
- Цахим төлбөр тооцооны асуудлаар Сангийн яамны төрийн сангийн газартай уулзалт зохион байгуулж "Төрийн үйлчилгээний цахим төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ"-г баталгаажуулах ажлыг яаравчлах талаар санал солилцсон. 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн Сангийн яамны төрийн сангийн газар, Монгол банкны төлөөлөлтэй хийсэн уулзалтаар төрийн үйлчилгээний мөнгөн дүнгээс шалтгаалан 2 интервалаар шимтгэлийг авахаар талууд тохиролцож, Монгол банк холбогдох журмандаа өөрчлөлт оруулахаар тогтсон болно. Талуудын хооронд байгуулах гэрээ батлагдсаны дараа цахим төлбөр тооцоотой холбоотой үйлчилгээнүүд ашиглалтанд нэвтэрнэ.
- ҮДТ УТҮГ-тай хамтарсан ажлын хэсгийн хурлыг 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, төслийн одоогийн нөхцөл байдал, гүйцэтгэж байгаа ажлуудын талаар товч танилцуулга хийж, ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг тусган ажиллав. Ажлын хэсгийн тайлан, хурлын тэмдэглэлийг боловсруулж гишүүдэд танилцуулсан.
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 20 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын 9 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхээр шийдвэрлэсний дагуу НДЕГ-ын 7 үйлчилгээний сервис холболттой холбоотойгоор МТШХХГ, НДЕГ, ҮДТ УТҮГ-ын хамтын ажиллагааны гэрээг баталгаажуулахаар НДЕГ-т албан бичгийн хамт хүргүүлсэн.

Иргэдийн өргөдөл, гомдлын ухаалаг тайлангийн систем төслийн гүйцэтгэгч Ньюсоник ХХК нь төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машины хяналт, мониторингийн програм хангамжийг боловсруулан Үндэсний дата төв УТҮГ-т хүлээлгэн өглөө. Монгол Улсын аймаг, сум суурин газар болон, нийслэлийн төр, хувийн хэвшлийн байгууллагуудаас ТҮЦ машиныг нэмж суурилуулах хүсэлт удаа дараа ирснийг харгалзан ТҮЦ машины үйл ажиллагааны талаар иргэдээс авсан судалгаанд үндэслэн ТҮЦ машиныг нэмж байрлуулах талаар танилцуулгыг бэлтгэн удирдлагад танилцууллаа.

Цахим засгийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар танилцуулга бэлтгэн 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн "Шийдлийн цаг"-аар танилцууллаа.

Тус газрын дарга болон Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын хамтарсан 2015 оны 84/А/31 дугаар тушаалаар хүүхдэд зориулсан монгол хэл дээрх сургалтын агуулгыг

нэмэгдүүлэх, цахим боловсрол олгох, интернэтийн зөв хэрэглээг бий болгох зорилгоор “Ухаалаг ном” бүтээх тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллалаа. Тэмцээний албан ёсны цахим хуудас болох [www.i-book.mn](http://www.i-book.mn) цахим хуудсаар нийт 14 баг бүртгүүлсэн бөгөөд оролцогч багууд Байгалийн ухаан, Нийгмийн Ухаан, Түүх соёл, Хүүхдийн хөгжил, Дэвшилтэт технологи гэсэн 5 сэдвийн хүрээнд вэб хөгжүүлж, Монгол хэл дээрх агуулга бүтээж оролцсон. Оролцогч багуудад вэб хийх анхан шатны мэдэгдэхүүн олгох, технологийн асуудлыг шийдвэрлэх, бүтээлийг чанаржуулах үүднээс мэргэжлийн багш нар 2 удаагийн сургалт зохион байгуулсан болно. Бүтээлийг 2015 оны 10 дугаар сарын 05 хүртэл хүлээн авч нийт 5 баг бүтээлээ ирүүлснээс шүүгчдийн үнэлгээгээр Дархан-Уул аймгийн Дархан 26 сургуулийн “E-KIDS” баг тодорч, 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр шагналыг гардуулав. Тус тэмцээнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Ажлын хэсгийн тэмцээний талаар болон гүйцэтгэсэн ажлын тайланг гаргаж, удирдлагад танилцуулав.

"Телевизийн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах стандарт" болон "Телевизийн үгэн болон дүрст мэдээллийн форматад тавигдах шаардлага" стандартын төслүүдэд саналаа боловсруулан Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэв.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод холбооны болон эрхзүйн орчныг сайжруулах зорилтод тусгагдсан Экспортод суурилсан эмбеддэд /Embedded/ систем болон чипэд суурилсан системийн технологийн судалгаа хөгжлийн төв байгуулах ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 онд Эмбеддэд систем хөгжүүлэлтийн лабораторийг Мэдээллийн технологийн үндэсний паркад байгуулсан. Тус лабораторийн үйл ажиллагаа, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Дэлхийн банкны санхүүжилтээр хоёр ширхэг Ultimaker 3D printer бүхий нээлттэй лаборатори /Open Lab/-ийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулав. Энэхүү лабораторид хэвлэгчээс гадна олон төрлийн электроникийн тоног төхөөрөмжүүдийг байршуулж, зохион бүтээгч, оюутан залуучуудад үнэ төлбөргүй ашиглуулж байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос БНСУ-ын Интернэт, аюулгүй байдлын агентлаг (KISA)-тай хамтран 2015 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан “GCCD Cybersecurity Seminar in Mongolia” семинарт мэдээллийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр, холбогдох хууль тогтоомж болон тус газраас мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр хийгдэж буй ажлуудын талаар танилцууллаа.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ирүүлсэн “Эрүүл мэндийн цахим мэдээлэлд хандах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам”-ын төсөлд 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 1/1081 тоот албан бичгээр санал өгч, хамтран ажиллав.

Тус газраас БНАСАУ-ын Програм хангамжийн Ерөнхий Газрын төлөөлөгчидтэй 2015 оны 08 дугаар сарын 06-нд хийсэн уулзалтын дагуу байгууллага хоорондын хамтын ажиллагааны санамж бичгийг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг 2016 оны төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөсөн талаар 12 дугаар сарын 01-ний өдрийн 1/1053 тоот албан бичгийг Гадаад хэргийн яам, БНАСАУ-ын Элчин сайдын яаманд хүргүүлэв.

“Өгөгдөл хамгаалах тухай” болон “Цахим Засгийн тухай” хуулийн төслийг боловсруулахад техникийн судалгаа, сургалт семинар зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ авахад дэмжлэг хүссэн 1/1112 тоот албан бичгийг ХХЗХ-д хүргүүлэв.

“Цахим үйлчилгээ-Ухаалаг төхөөрөмж” төслийг танилцуулгын хамт дотоодын болон гадаадын 44 байгууллагад хамтран ажиллах хүсэлт илгээснээс 7 байгууллагаас хариу ирээд байна. Үүнээс Японы ICC (The International Cooperation for Computerization) байгууллага хамтран ажиллах хариу ирүүлсэн бөгөөд тус газрыг Японы хувийн компаниудтай холбох, тэдгээр байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллах шаардлагатай болох, эрчим хүчний болон давтамжийн зөрүү гарах, үүнийг хэрхэн шийдэх талаар тодруулга бүхий мэдээ ирүүлээд байна. Уг ажлын хүрээнд МТҮП-ын даргатай 2015 оны 12 дугаар сарын 14-ны өдөр уулзаж, уг төслийг хамтран хэрэгжүүлэх, холбогдох Японы байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллах хүсэлт тавьж, хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд Японы ICC байгууллага руу ухаалаг төхөөрөмжийн шаардлагатай техникийн тодорхойлолтыг илгээгээд байна.

Тус газрын удирдлагууд БНСУ-ын Интернэт, аюулгүй байдлын агентлаг (KISA)-ийн Дэд ерөнхийлөгч Чо Юнхонг тэргүүтэй төлөөлөгчдийг 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтаар төлөөлөгчид хамтын ажиллагааг эрчимтэй үргэлжлүүлэн ажиллахаа мэдэгдэв. Мөн тус агентлагаас хэрэгжүүлж буй CAMP (Cyber security Alliance Mutual Progress) төслийн хүрээнд 28 улс нэгдэн ороод байгаа бөгөөд Монгол Улсыг гишүүнчлэлд нэмэх, Хамтын нийгэмлэг байгуулах талаар ирэх онд хамтран ажиллах талаар санал солилцов.

Японы тэргүүлэх аж үйлдвэрийн шинжлэх ухаан, технологийн хүрээлэн, Японы мэдээлэл, харилцаа холбооны хорооны гишүүн Х.Окамура болон Япон улсын ОСС компаний гадаад зах зээлийн асуудал хариуцсан менежер М.Ишикава нартай хамтарсан “Хуягт шилэн кабелийн стандартчилал” уулзалт семинарыг 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгууллаа. Семинарт тус газраас холбогдох мэргэжилтэн “Монгол Улсын хөдөө орон нутгийн өргөн зурвасын сүлжээ, үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдэвт илтгэл тавилаа. Газрын удирдлагуудтай эдгээр төлөөлөгчдийг уулзуулж хуягт шилэн кабелийн туршилтын хамтарсан төсөл хэрэгжүүлэх боломжийн талаар санал солилцлоо.

“Алслагдсан 33 сумдыг шилэн кабелийн сүлжээгээр холбох” төслийн танилцуулга, хөрөнгө оруулалтын тооцоог боловсруулж Дэлхийн банкны Ази, номхон далайн бүсийн асуудал хариуцсан салбар (Дэнзэн Норбу Дулма, Наташа Бесчорнер) болон ОУЦХБ-ын Япон дахь салбарт (Я. Кавасуми) тус тус хүргүүлэв.

**Гурав. Мэдээлэл харилцаа холбоо технологийн салбарын төсөл, хөтөлбөрийн удирдлага зохицуулалт, бодлогын удирдамжаар хангах**

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Сумдад өндөр хурдны өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах” төслийг 2012-2013 онд хэрэгжүүлж дуусгасан. Уг төслөөр Монгол Улсын нийт 11 аймгийн 90 сумын Засаг Даргын тамгын газар, Эмнэлэг, Ерөнхий боловсролын сургуулиудыг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбож, нийтэд зориулсан утасгүй интернетийн сүлжээ (WIFI)-г 21 аймгийн төв болон 2 дүүрэг, Шувуун фабрик, Биокомбинат сууринд байгуулсан ба сумдад суурилуулсан тоног төхөөрөмжид хяналт шалгалт хийх Улсын комиссын актыг үйлдэж холбогдох материалуудыг бэлтгэн ашиглалт үйлчилгээ хариуцагч байгууллагад хүлээлгэн өгөхөөр Төрийн өмчийн хороо руу албан тоот хүргүүлээд байна.

Болгарын Ерөнхийлөгч Монгол Улсад айлчлан ирсэнтэй холбогдуулан тус газрын удирдлага Монгол Улсын МХХТ-ийн өнөөгийн байдлын талаар танилцуулга хийв.

Газрын даргын 2014 оны 314 тоот тушаалаар байгуулагдсан “Нийслэлийн мэдээлэл, харилцаа холбооны сүлжээг хөгжүүлэх бодлого боловсруулах” ажлын хэсэг 2 удаа хуралдан, нийслэлийн сүлжээний шинэчлэл, өөрчлөлтийн асуудлыг Мэдээлэл, холбооны сүлжээ ХХК-ний хувьчлалтай уялдуулан шийдвэрлэх нь оновчтой гэсэн дүгнэлт гаргасан. Түүнчлэн, нийслэл хотын барилгажилттай холбоотойгоор хэрэглэгчдийн эрх ашгийг дээдлэх, тэдэнд мэдээлэл, харилцаа холбооны олон төрлийн үйлчилгээнээс сонгох боломжийг бүрдүүлэхийн тулд хэрэглэгчийн сүлжээг “Монголын цахилгаан холбоо” ХК-нийн өмчлөлөөс “Мэдээлэл, холбооны сүлжээ” ХХК-нийн өмчлөлд шилжүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт хийсэн болно.

Засгийн газрын 2012-2016 оны хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Сумдын нэг үйлчилгээний төв” байгуулах зорилтын хүрээнд “Сумын нэг цэгийн үйлчилгээний төв” байгуулах төслийн судалгаа хийж байна.

**Мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэл төслийн хүрээнд:**

- Сангийн яамнаас зохион байгуулсан гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжүүд цаашид хэрхэн ажиллах, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудлаар санал солилцох семинарт оролцов.



- Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд “Мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэл” төслийн 2014 оны санхүүгийн тайланг орууллаа.
- Мэдээлэл холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэл төслийн хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-тай гүйцэтгэлийн зураг хүлээлгэн өгөх талаар уулзалт зохион байгуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг гарган Төслийн гүйцэтгэлийн зургийн материалыг орон нутгийн салбаруудад хүргүүлэв.
- Төслийн үйл ажиллагааны тайланг боловсруулан Сангийн яаманд хүргүүлэв.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар батлагдсан "Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй болгох" хөтөлбөрийн Багц 5 буюу "Ухаалаг шуудангийн хайрцаг" төслийн хэрэгжилт, ашиглалт, хэвийн үйл ажиллагааг шалгах ажлын хэсэг ажиллаж Ухаалаг шуудангийн хайрцагны хэрэглээ өнөөгийн байдал, техник технологи, хүртээмжийг судлан, дүгнэлт гаргав.

Шуудангийн менежмент, төрийн болон хувийн хэвшлийн компани, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран ажиллах уялдаа холбоог сайжруулах, тэдний хамтын ажиллагааны талаар судалгаа хийлээ.

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын бүх төрлийн мэдээллийг боловсруулах, газарзүйн мэдээллийн системийг хэрхэн хөгжүүлэх, өгөгдөл бэлтгэх тухай уулзалтыг Газрын харилцаа геодези зурагзүйн газрын холбогдох албаны хүмүүстэй уулзаж хамтран ажиллахаар болов.

Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлсэн “Монгол хэлний зөв бичгийн дүрмийн алдаа шалгах програм хангамж бий болгох” ТН-09-01/12 төслийн програм хангамж, тоног төхөөрөмжийг хариуцагч байгууллагад хүлээлгэн өгөхөөр Төрийн өмчийн хороо руу албан тоот хүргүүлээд байна.

Мэдээлэл, харилцаа холбооны статистик мэдээллийн цахим самбар хийхээр Монгол Улсын газрын зураг дээр суурилан өгөгдөл оруулах ажлын хэсгийг тус газрын даргын 2015 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 225 тоот тушаалаар байгуулав. Энэхүү ажлын хэсгийн хүрээнд Газрын харилцаа, геодези, зурагзүйн газраас тоон суурь зургийг албан тоотоор хүлээн авч боловсруулалт хийж байна.

Тус газраас 2015 онд хэрэгжиж буй төслүүдийн талаарх судалгааг нэгтгэж Сангийн Яаманд хүргүүлэв.

Төрийн өмчийн хороонд 2015 онд нийт 17,638,496,468 төгрөгийн 7 төслийг салбарын төрийн өмчит компаниудын хөрөнгөд шилжүүлсэн. Одоо шилжүүлэхээр

ажиллаж байгаа 5 төсөл, шилжээгүй 21 төслийн холбогдох материаллыг бүрдүүлэн ажиллаж байна.

**Дөрөв. Төрийн захиргааны удирдлага, манлайллыг хангах, хүний нөөцийн удирдлагын хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, санхүү болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, дэмжлэг үзүүлэх**

Монгол Улсын Ерөнхий сайдын “Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 2015 оны 40 дугаар захирамжийн дагуу Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын бүтэц, орон тоог газрын даргын 2015 оны 52 дугаар тушаалаар батлуулав.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус газрын 7 албан хаагчийг газрын даргын 2014 оны 317 тоот тушаалаар албан тушаалаас нь чөлөөлж, зохих тэтгэмжийг олголоо.

Тус хэлтсээс 2015 онд газрын хэмжээнд үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэрэгжүүлэх дараахь дүрэм, журмыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

- Хөдөлмөрийн дотоод журам
- Удирдлагын зөвлөлийн хурлын бүрэлдэхүүн, хурлын дэг
- Байгууллагын архивын дүрэм
- Албан хэрэг хөтлөлтийн журам
- Ёслол, хүндэтгэл протоколын журам
- Байгууллагын 2015-2017 оны хэтийн төлөвлөгөө
- Гамшгаас хамгаалах улсын албаны бүрэлдэхүүн

Тус газрын Удирдлагын зөвлөлийн хурлын бүрэлдэхүүн, дэгийг газрын даргын 2015 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Тус газрын үйл ажиллагааны тайланг сар, улирал, хагас жил, жилээр нэгтгэн боловсруулж, удирдлагад танилцуулан, тайлант хугацаанд нь Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тогтмол хүргүүлэн ажиллалаа.

Монгол Улсад “Орчин цагийн харилцаа холбооны салбар үүсч хөгжсөний 94 жил”-ийн ой, “Цахилгаан холбоо, мэдээлэлжсэн нийгмийн Дэлхийн өдөр”-ийг тус тус тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд салбарын хэмжээнд уламжлал болгон 9 дэхудаагаа ICT-EXPO-2015” үзэсгэлэн “Мишээл экспо” төвд 2015 оны 5 дугаар сарын 21-нээс 25-ны өдрүүдэд “Бидний шийдэл – Хөгжлийн хурдасгуур” уриан дор зохион амжилттай зохион

байгууллаа. Үзэсгэлэнгийн үеэр уралдаан тэмцээн, оддын тоглолт, харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын чиг хандлагыг тодорхойлох гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих “Start-Up Weekend” зэрэг сонирхолтой үйл ажиллагаа явуулсан.

Ази-номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллага нь гишүүн орнуудынхаа сансрын технологийн хөгжлийг дэмжих, хүний нөөцийг чадавхижуулах зорилгоор “Сансрын технологийн хэрэглээ” чиглэлээр Доктор(DOCSTA), Магистр (MASTA)-ийн зэрэг олгох тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тус хөтөлбөрт Монгол Улс 2008 оноос хойш оролцож байгаа бөгөөд тус газраас Монгол Улсын сансрын технологийн салбарт ажиллах мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилгоор 2015 оны элсэлтийг 2015 оны 2 дугаар сарын 12 өдрөөс эхлэн нээлттэй зарлаж, тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг газрын даргын тушаалаар байгуулсан. Шалгаруулалтанд магистрийн зэрэгт суралцахаар нийт 8 өргөдөл гаргагч, докторын зэрэгт суралцахаар нийт 2 өргөдөл гаргагчийн материал хүлээн авч, тавигдсан шалгуурын дагуу дүгнэж, бичиг баримтын шалгаруулалтад тэнцсэн (магистр- 6 хүн, доктор-1) өргөдөл гаргагчидтай ярилцлага хийн, өргөдлийн материалуудыг Ази-номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагад хүргүүлэв.

МТШХХГ-ын төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний 2015 оны тайланг гарган, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв.

Газрын даргын зөвлөлийн хурлыг тогтмолжуулж долоо хоног бүрийн Мягмар гарагт хуралдуулж байгаа ба 9 удаагийн хурлаар 14 асуудлыг хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг баримтжуулж хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллалаа.

Газрын нийт албан хаагчдын Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд Мэдүүлгийн програмд цахимаар болон цаасаар хүлээн авч, Хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүнийг хэрхэн бөглөх талаарх зааварчилгааг өгч, Авлигатай тэмцэх газарт албан тушаалтнуудын 2014 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /хураангуй/, Мэдүүлгийн 2014 оны тайланг хүргүүлсэн. Тус газрын Авлигаас урьдчилан сэргийлэх Авлигын эсрэг 2015 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. 2014 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр төлөвлөгөөний биелэлтийг холбогдох материалын хамт Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн 98.2 оноо авч Засгийн газрын харьяа агентлагуудаа тэргүүллээ.

Гамшгийн аюулыг зарлан мэдээллийн дохио дамжуулах журмын дагуу зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага сургуулийг тус газар болон салбар, харьяа байгууллагын хэмжээнд 2015 оны 3 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулав.

Тус газраас Монгол Улсад орчин цагийн мэдээлэл холбооны салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойг 2016 онд тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлыг хангахтай

холбогдуулан МТШХХГ-ын даргын 2015 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 114 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Албан хаагчдад зориулан “Мэдээллийн цаг” хөтөлбөрийг долоо хоног бүрийн Баасан гарагт төлөвлөгөөний дагуу нийт 16 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, тухайн жилийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцэст тооцон дараа жилийн сургалтын хэрэгцээг тодорхойлохоор төлөвлөөд байна.

Тус газар болон БНСУ-ын Мэдээлэл харилцаа холбооны технологийг дэмжих хүрээлэнгийн хооронд TOPCIT шалгалтын системийг Монголд нэвтрүүлэхээр Харилцан ойлголцлын санамж бичгийг зурж хамтын ажиллагааг эхлүүлээд байна.

Тус газраас 2015 онд нийт давхардсан тоогоор нийт 63 албан хаагч гадаад арга хэмжээ, сургалтанд хамрагдсан.

#### Хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх талаар

Дараахь чиглэлээр тухай бүр холбогдох зөвлөгөө, дэмжлэгийг үзүүлж ажилласан.

- Дээд газрын шийдвэрээр болон газрын даргын тушаалаар батлуулах бодлогын баримт бичиг, дүрэм, журмын төсөл
- Газрын даргын тушаалын төсөл
- Гэрээ хэлцэл, санамж бичгийн төсөл
- Явсан бичгийн хууль зүйн үндэслэл, утга найруулга
- Бусад байгууллагаас санал авахаар ирүүлсэн хуулийн төсөл, дүрэм, журмын төсөл
- Салбарын хууль тогтоомж, дүрэм, журмын судалгаа
- Албан хаагчдад хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх
- Шүүхэд байгууллагаа төлөөлөх

#### Хянаж ажилласан гэрээ хэлцэл, санамж бичгүүд

- “Төрийн үйлчилгээний нэгдсэн веб порталын модулиуд хөгжүүлэлт төсөл”-ийн хүрээнд Монгол банктай байгуулах Хамтран ажиллах гэрээний төсөл
- Ерөнхий боловсролын сургуулиудад интернэтийн үйлчилгээ үзүүлж байгаа МХС ТӨХХК, Эрдэмнэт ХХК, МЦХ ХК, Юнивишн ХХК, БСШУЯ-тай хамтарсан 3 талт Интернэтийн үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөл
- “Газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем байгуулах” ТН-12/12 дугаартай төслийн гүйцэтгэгчтэй байгуулах нэмэлт гэрээний төсөл
- Үндэсний дата төв УТҮГ-тай байгуулах “Зохиомол сервер түрээслэх тухай гэрээ

- БНҮҮС-ын “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээнд тулгуурлан хөдөө орон нутагт интернетийн хэрэглээг нэмэгдүүлэх, хөгжүүлэх” үйлчилгээ үзүүлэх 2014-Ү-ХААГ/А/177 дугаартай гэрээний нэмэлт, өөрчлөлт
- “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн системийг удирдах хамтран ажиллах гэрээ”
- Төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэх ажлын 3 талт гэрээ
- “МУ-ын нутаг дэсвгэрийг дамжин өнгөрөх улс хоорондын транзит урсгал дамжуулах үйлчилгээний тухай” МХС ТӨХХК, Жемнэт ХХК, Мобиком нэтворкс ХХК-тай хамтарсан санамж бичиг
- “Мэдээлэл, харилцаа холбооны салбарын үндэсний орон зайн мэдээллийн сан үүсгэх тухай” ГХГЗЗГ-тай хамтарсан санамж бичиг
- “Мэдээлэл, харилцаа холбооны салбарын статистик мэдээллийг нэмэгдүүлэх, хамтран ажиллах тухай” ХХЗХ, ҮСХ-той хамтран байгуулах санамж бичиг

➤

Шагнал урамшуулал:

Газрын даргын 2015 оны 143, 177, 234, 248, 283 дугаар тушаалаар

- Мэдээлэл харилцаа холбооны тэргүүний ажилтан тэмдгээр 282
- Шуудангийн тэргүүний ажилтан тэмдгээр 26
- МТШХХГ-ын хүндэт жуух бичгээр 220

Хүндэт холбоочин үнэмлэх энгэрийн тэмдгээр салбарын 108 ажилтан албан хаагч, өндөр настныг тус тус шагнав

Байгууллагын ажилтан албан хаагчдын ажлын үр дүн гаргасан амжилтыг үндэслэн:

- Төрийн дээд шагналаар 2,
- Салбарын тэргүүний ажилтнаар 5,
- МТШХХГ-ын Хүндэт жуухаар 10,
- МЗХ-ны тэргүүний залуу алтан медалиар 3,

Монголын залуучуудын холбооны Хөдөлмөрийн алдар алтан медиалаар 3 хүн шагнуулах ажлыг зохион байгууллаа

а. Тогтоол, шийдвэрийн биелэлтийн талаар

Тус газраас хариуцан хэрэгжүүлэхээр Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-ын болон Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжийн биелэлтийг тухай бүр бүртгэл хөтлөн хянаж, ЗГХЭГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) цахим системд улирал тутам биелэлтийг оруулан ажиллаж байна.

б. Өргөдөл гомдлын талаар

Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэхтэй холбогдуулан санал, хүсэлтийн хайрцаг нээн ажиллуулж байна. Тус газарт 2015 онд нийт **49** өргөдөл ирснийг хүлээн авч бүртгэн холбогдох албан тушаалтанд шилжүүлэн зохих хууль журмын дагуу шийдвэрлэн ажиллаж байна.

Засгийн Газраас “11-11 ТӨВ”-ийг байгуулж иргэддээ нээлттэй, тунгалаг төрийг цогцлоохын тулд хүнд суртлыг халж, хурдан шуурхай үйлчилгээг эрхэмлэж, иргэдийн саналыг арван сувгаар хүлээн авч, хариулт өгөхтэй холбоотойгоор иргэдээс мэдээллийн технологийн чиглэлийн нийт **142** талархал, гомдол, шүүмжлэл, санал хүсэлт ирүүлснийг хүлээн авч, тухай бүрт нь шуурхай шийдвэрлэн, холбогдох арга хэмжээг авч, ажиллаж байна.

в. Архив албан хэрэг хөтлөлтийн талаар

Газрын албан хэрэг хөтлөлтийг Албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврыг мөрдлөг болгон ажиллаж ирлээ. Архивын ажлын үндсэн заавар, Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар мөрдлөг баримт бичгүүдийн бүрдэл тус бүрт тавигдах шаардлагыг тухай бүрд нь ханган ажиллалаа. Архивын улсын үзлэгт тус газар 91.7 хувийн амжилт үзүүлэн А үнэлгээг авсан болно.

Тус газарт ирсэн баримт бичгийг хүлээн авах, бүртгэх, явуулсан бичгийг бүртгэх, өргөдөл гомдлыг бичиг хэргийн бүртгэл, хяналтын программд бүртгэн хяналтын карт хөтлөн баталгаажуулан ажиллаж ирлээ.

Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг болохтой холбогдуулан дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгууллагын Архивын дүрэм, албан хэрэг хөтлөлтийн зааврыг шинэчлэн батлуулсан.
- Баримт бичиг нягтлан шалгах комисс байгуулах, комиссын дүрэм, ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.
- Архивын ажилтаны мэргэшсэн сургалтанд хамрагдаж мэргэшлийн сертификат авсан.
- Албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн баяжилтыг хийлээ.
- Байгууллагын архивын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчилсэн.
- Архивын тухай хууль, тогтоомж байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу архивын өрөөг тохижуулж, шаардлагатай хэрэгслүүдийг байршуулсан.
- Тус газрын нийт албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт зохион байгуулав.
- Тус газрын Албан хэрэг хөтлөлтийг зааврын дагуу ирсэн, явуулсан бичигт хяналт хөтлөлт хийн ажиллаж байна.

Агуулга	Тоо хэмжээ
Тус газарт ирсэн бичиг	<b>981</b>
Үүнээс карттай хариу явуулсан	
Тус газраас явуулсан албан бичиг	<b>1095</b>

Шууданд хаяглаж, дугтуйлж	1095
Хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо	
Газрын даргын тушаал	245
Дээд газраас ирүүлсэн шийдвэр, тэмдэглэл	
Иргэд, ажиллагсдаас ирүүлсэн өргөдөл	49
Хариуг явуулсан болон хаасан	49

Газрын шуурхай зөвлөгөөний хурлыг 7 хоног бүрийн даваа гарагт зохион байгуулсан байна. Тайлант хугацаанд:

- Хуралдсан шуурхай зөвлөгөөний тоо 44
- Хурлаас өгөгдсөн үүрэг, даалгавар давхардсан тоогоор 672

**Санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, салбарын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах**

г. Төсөв санхүүгийн талаар

Тус газрын 2015 онд батлагдсан 8 124 829,3 мян. төгрөгийн (тодотгосон) төсвийг сар, улиралын хуваарийн дагуу зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, сар, улирлын тайлан мэдээг ЗГХЭГ-т тухай бүр хүргүүлж ажиллалаа.

Үндэсний аудитын газраас тус газрын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит орж Зөрчилгүй хангалттай гэсэн үнэлгээ авсан.

Бараа материал болон үндсэн хөрөнгийн тооллогыг хагас жилээр хийж Үндсэн хөрөнгө хамгаалах комиссын дүгнэлтийг гаргууллаа.

Төрийн өмчийн хороонд хөрөнгийн ТӨХ болон ТӨ маягыг бөглөж цахимаар илгээж нэгтгэн Төрийн өмчийг эзэмших гэрээг дүгнүүлэн хангалттай үнэлгээг авсан.

Тус газрын 2015 оны хагас жилийн санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргаж Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тайлан, Сангийн яамны цахим тайлангийн систем, Төрийн өмчийн хорооны цахим бүртгэлд хуулийн хугацаанд нь шивж нэгтгүүлсэн бөгөөд 2015 оны 3-р улирлын санхүүгийн тайланд явцын аудит ороод байна.

Тус газрын 2016 оны төсвийн төсөл, 2017-2018 оны төсвийн төсөөллийг боловсруулан Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн бөгөөд харьяа байгууллагуудын төсвийн төслийг нэгтгэн сангийн яамны нэгтгэлийн системд шивж хүргүүллээ.

МТШХХГ-ын 2016 оны төсвийн зарлага нийт 5 145 198,7 сая төгрөгөөр батлагдаж өмнөх 2014 оныхоос зардал нэг бүрийг 40%-50% хүртэл бууруулж баталсан байна.

**Тав. Статистик мэдээ, мэдээллийн хэрэгцээг хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавьж удирдамж зөвлөмжөөр хангах.**

Үндэсний хөгжлийн цогц бодлогын 2014 оны тайлан боловсруулж Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн системд оруулж баталгаажуулсан. Мөн 2015 оны тайланг маягтын дагуу нэгтгэн боловсруулж холбогдох газарт хүргүүлсэн.

Стандартын чиглэлээр дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Стандартчиллын 2015-1016 оны төлөвлөгөөнд тусгуулах санал боловсруулж бусад, газар, хэлтсүүдийн саналтай нэгтгэн Харилцаа холбооны Зохицуулах хороо, Стандартчилал, хэмжил зүйн газарт тус тус хүргүүлэв.
- АНДЦХБ-ын Стандартчиллын 25 дугаар чуулганд хэлэлцэх материалуудтай танилцаж, МХХ-ны салбарын стандартчиллын талаар танилцуулах мэдээлэл боловсруулсан. Стандартчиллын хөтөлбөрийн судалгааны бүлгүүдтэй эргэх холбоотой ажиллаж ирсэн судалгааны асуулгаар холбогдох мэргэжилтнүүдийг холбож хариу илгээж ажиллалаа.
- Стандартын техникийн хорооны хуралд 3 удаа оролцож 20 гаруй стандартын төслийг хэлэлцэж санал өгөв.
- Тайлангийн хугацаанд тус газраас стандартын төсөлд өгсөн саналын судалгаа гаргаж, тус газраас 10 гаруй мэргэжилтэн 16 стандарт, нэг гарын авлагын төсөлд санал өгч ажилласан байна.
- Стандартчиллын 2016-2017 оны төлөвлөгөөний асуудлаар хэлтэс, албадын мэргэжилтнүүдэд танилцуулга хийж саналыг нэгтгэж Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэв.

## **II. Хяналт шинжилгээ**

Харъяа байгууллагуудын 2014 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж тайлан зөвлөмжийг тус газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүнг нэгтгэн хүргүүлсэн ба холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээний 2014 оны, 2015 оны эхний хагас жилийн тайланг хугацаанд нь гаргаж ЗГХЭГ-т хүргүүлж, мэдээллийн системд оруулсан. Энэ асуудлаар ЗГХЭГ, СЯ болон аудитаас шаардсан мэдээллийг тухай бүрт нь гаргаж өгч ажиллав.



Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 2015 оны хэрэгжилтэд хяналт тавьж эхний хагас жилийн болон жилийн эцсийн тайлан, мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж ажиллалаа.

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээний ажлын хүрээнд яамд, агентлагууд, нийтдээ 50 гаруй газраас 2014 оны тайлан, мэдээллийг авч “Үндэсний хиймэл дагуул”, “Цахим засаг”, “Өрх бүрт шуудан”, “Радио телевизийн өргөн нэвтрүүлгийн тоон технологид шилжүүлэх”, “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах”, “Өргөн зурвасын өндөр хурдны сүлжээ” зэрэг 6 хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээний тайланг холбогдох журмын дагуу гаргаж ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн үндэсний хөтөлбөрүүдийн 2015 оны тайлан, мэдээллийг цуглуулан хяналт-шинжилгээ хийж хугацаанд нь дээд газарт хүргүүлэхээр ажиллаж байна.

Тус байгууллагад ирсэн өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийг талаарх архивын хавтаст материалууд, 2015 оны бүртгэл хяналттай танилцан шинжилж /2009-2015он/ танилцуулга, судалгаа хийсэн.

Газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт шинжилгээ хийж тайлан, санал зөвлөмжийг Удирдлагын зөвлөлийн хуралд хэлэлцүүлж, гарсан шийдвэрийн дагуу төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тушаалын төсөл боловсруулж батлуулсан.

#### Хөрөнгө оруулалтын арга хэмжээ

Тус газрын 2010 оноос хойш хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Улсын төсвийн хуультай тулгаж тендерийн дугаарын мэдээлэл гаргав.

Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны I-III улирлын тайланг хугацаанд нь гаргаж ЗГХЭГ, СЯ-нд хүргүүлж явцын талаарх мэдээллийг e-procurement.mn мэдээллийн системд тухай бүрт нь оруулж ажилласан.

ҮАГ, ЗГХЭГ, СЯ байгууллагуудаас тус газрын хариуцсан хөрөнгө, оруулалтын төсөл, арга хэмжээний талаар шаардсан мэдээллийг тухай бүрт гаргаж өгч ажиллав.

Төсвийн 2016 оны хязгаарын хүрээнд төслийн жагсаалт гаргаж харьяа газруудын саналыг нэгтгэн мэдээлэл, харилцаа холбооны салбарын бодлого, хөтөлбөр, зорилтуудтай уялдуулан боловсруулсан.

Улсын 2016 оны төсвийн төсөлд орох нууцын төслийн жагсаалтыг маягтын дагуу гаргаж ЗГХЭГ,СЯ-д хүргүүлсэн.

### **III. Төсөл хөтөлбөрийн хяналт-шалгалт**

Тоон телевизийн төслийн хүрээнд байгуулсан хяналтын сэттоп боксын гэрээ, тендерийн материалтай танилцаж, дүгнэлт гаргав.

“Цахим засаглалын мэдээллийн сан, мэдээллийн системийг бий болгох төсөл”-ийн хүрээнд улсын төсвийн санхүүжилтээр 2012-2014 онд хэрэгжүүлсэн “Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хянах мэдээллийн системийг бий болгох”, “Иргэдийн өргөдөл, гомдлын мэдээллийн ухаалаг тайлангийн систем” төслүүдийн тайланг нэгтгэн Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газарт албан бичгээр хүргүүлсэн. Мөн “Иргэдийн өргөдөл, гомдлын ухаалаг тайлангийн систем”, “Иргэдийн өргөдөл, гомдлыг хянах мэдээллийн системийн бий болгох” төслүүдийн хүрээнд боловсруулсан албан бичиг, гэрээний хуулбарыг архиваас авч нэгтгэн, холбогдох тоо баримтыг тодруулан 3 хавтас болгон цэгцэлсэн.

Тус газраас МХХ-ны хяналтын улсын байцаагчийн эрх нэмж авах асуудлаар үндэслэл, шаардлага боловсруулж холбогдох хүмүүсийн материалыг бүрдүүлэн Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэв.

БНҮҮС-аас зарласан “Тоон телевиз, радиогийн хэрэглэгчийн хүлээн авах төхөөрөмжийг Монгол Улсад нэвтрүүлэх хэрэглэгчийн судалгаа” гүйцэтгэх Т/Ш/Д-ТН-05/05 тендерийн ажлын даалгавар, үнэлгээний хорооны дүгнэлтийг шалгаж дүгнэлт гаргах ажлын хэсэгтэй хамтран ажиллаж холбогдох баримт, материалтай танилцан асуудлыг судалж санал, дүгнэлт гаргасан.

#### **IV. Статистик мэдээлэл**

Байгууллагын цахим мэдээллийн сангийн тухай журмыг газрын даргын 15 тоот тушаалаар батлуулсан. Хэлтэс, албаны админуудад журмыг танилцуулж, арга зүйн зөвлөгөө өгч, мэдээллийн сангийн нэгдсэн зохион байгуулалт хийсэн.

Үндэсний статистикийн хорооноос санаачилсан мэдээлэл, харилцаа холбооны статистик үзүүлэлтүүдийг тооцох аргачлалын төсөлд санал боловсруулж хариу явуулав. Тус хорооны даргын зөвлөлийн хуралд оролцож өгсөн саналаа хамгаалж аргачлалыг батлуулав.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын статистик мэдээлэл, “их өгөгдөл”-ийг хөгжүүлэх чиглэлээр МТШХХГ, ХХЗХ, ҮСХ байгууллагуудын хамтран ажиллах санамж бичгийн төсөл боловсруулж санал авахаар хоёр байгууллагад албан бичиг хүргүүлээд байна.

“Цагаан ном 2014” Англи хувилбар, мэдээллийн технологийн оны хүний мэдээг тус тус байгууллагын цахим хуудсанд тавьж нийтэлсэн.

Цагаан номын 2015 оны сэдэв, агуулгыг гаргаж холбогдох мэдээллийг цуглуулж судалж, график, текст боловсруулж хянуулан 500 хувь хэвлүүлсэн бөгөөд жилийн турш тарааж хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллаж байна.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон үндэсний 6 хөтөлбөрийн 2014 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тайлан, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн мэдээг хэлтэс, алба болон зарим мэргэжилтэнд файлаар явуулж мэдээллээр хангав.

МХХТ-ийн салбарын цахим мэдээллийн самбар байгуулах төслийн баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд:

- Салбарын байгууллагуудаар явах ажлын хуваарь гаргаж Мэдээллийн технологийн үндэсний парк, Харилцаа холбооны зохицуулах хороо, Радио, сүлжээ УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК, Монгол шуудан ТӨХК, Монголын цахилгаан холбоо ХХК зэрэг байгууллагууд дээр очиж дашбордын төслийн талаар танилцуулж харилцан санал солилцсон.
- Байгууллага тус бүрээс авч болох мэдээллийн жагсаалт авч төслийн баримт бичигт тусган боловсруулсан.
- “Глобал инновацийн индекс-2014”, өрсөлдөх чадварын индекс, мэдээллийн технологийн индекс зэрэг олон улсын судалгааны материалуудыг уншиж танилцан мэдээлэл боловсруулж баримт бичгийн төсөлд тусгасан.

## **МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗАР**